



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 1/36

Шивээговь сум

Тусгаарлах байр бэлтгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, б, л, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, 11.2.3, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар тогтоол “Зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээх, зарим хязгаарлалтын арга хэмжээ авах тухай”, Шадар сайдын 2020 оны “Удирдамж батлах тухай” 04 дүгээр тушаал, тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Шинэ коронавирусийн халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх талаар авч буй арга хэмжээний хүрээнд Шивээ Сервис ХХК-ийн Зочид буудал, Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр болон Спорт заалыг тусгаарлах байр болгосугай.

2. Дээрх байгууллагуудтай гэрээ байгуулж, тусгаарлах байр бэлэн болгохыг Засаг даргын Тамгын газрын дарга, онцгой комиссын орлогч дарга /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч, онцгой комиссын гишүүн /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212 0086